



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг шуудангаар болон цахимаар тус тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Баяр <b>Ургийн овог:</b> Боржигин <b>Нэр:</b> Пүрэвдагва <b>Хүйс:</b> эрэгтэй <b>Төрсөн он:</b> 1974 <b>Нас</b> 49 /45 нас хүрсэн/ <b>Төрсөн газар:</b> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг <b>Иргэний харьяалал:</b> Улаанбаатар хот <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот Баянгол дүүрэг /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Төрийн албаны зөвлөлийн гишүүн
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.4	<b>Төрийн албан хаагч</b> Төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан /хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. 2023.03.05 Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга 2021.08.15-2023.03.05 Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга 2020.01.06-2021.01.16 Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн ахлах референт 2021.01.16-2019.05.01 Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны Сонгон шалгаруулалтын газрын ахлах референт 2017.04.24-2019.05.01 Улсын Их Хурлын Тамгын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ахлах зөвлөх, Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах референт

	<p>2013.06.24-2016.10.16 Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны Шүүхийн хүний нөөцийн газрын хүний нөөц хариуцсан референт, ахлах референт, Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <p>2005.03.16-2013.04.24 Нийслэлийн боловсролын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга</p> <p>2005.02.16-2005.03.16 Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуулийн зөвлөх</p> <p>2001.09.21-2005.02.16 Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан зохион байгуулагч, Хороо хариуцсан зохион байгуулагч, Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн .</p>
<p><b>1.5</b></p>	<p><b>Боловсрол</b></p> <p>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. /Төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн;/</p> <hr/> <p>2008.06.01 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи-Удирдахуйн ухааны магистр.</p> <p>2000 онд Түшээ ХЗСургууль-Эрх зүйч</p> <p>Мэргэшсэн байдал</p> <p>2001-2024 оны 1 сар хүртэлх хугацаанд “Бодлогын баримт бичиг боловсруулах”, “Хүний нөөцийн менежмент”, “Мэдээллийн технологи”, “Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалт”, “Хуулийн төсөл боловсруулагчийн анхан шат” зэрэг богино, дунд хугацааны сургалтад гадаад, дотоодод суралцан мэргэжил дээшлүүлсэн.</p>

1.6	<p><b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p>
	<p>2023.03.05 Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга 2021.08.15-2023.03.05 Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга 2020.01.06-2021.01.16 Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн ахлах референт 2021.01.16-2019.05.01 Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны Сонгон шалгаруулалтын газрын ахлах референт 2017.04.24-2019.05.01 Улсын Их Хурлын Тамгын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ахлах зөвлөх, Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах референт 2013.06.24-2016.10.16 Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны Шүүхийн хүний нөөцийн газрын хүний нөөц хариуцсан референт, ахлах референт, Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга 2005.03.16-2013.04.24 Нийслэлийн боловсролын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга 2005.02.16-2005.03.16 Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуулийн зөвлөх 2001.09.21-2005.02.16 Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан зохион байгуулагч, Хороо хариуцсан зохион байгуулагч, Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн .</p>
1.7	<p><b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b> Сүүлийн нэг жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	<p>Үгүй .</p>
1.8	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ /Ял шийтгүүлж байгаагүй/</p>
	<p>Үгүй .</p>
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	<p>Үгүй</p>
1.10	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b> -Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p>
1.11	<p><b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b></p>

	<p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>
--	--

**ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР**

<p>2.1</p>	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p>.Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албыг 1990 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд төрийн байгууллагын шинэ тогтолцоог үүсгэх, төрийн мэргэшсэн албыг бүрдүүлэх, засаглалын институциудын чадавх үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх зэрэг үе шатыг туулан үргэлжилж байна.</p> <p>Төрийн албаны шинэтгэл эрчимтэй өрнөсөн эдгээр он жилүүдэд төрийн албан хаагчийн үүрэг, эрх мэдэл, хүлээх хариуцлагын тогтолцоог шинээр бүрдүүлэх замаар эрх зүйн байдлыг нь тодорхой болгох асуудал төрийн бодлогын цөм нь болж хууль тогтоогчдын анхаарлын төвд оршсоор ирсэн.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1-д “Иргэдэд адил тэгш хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтлана”, 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.3.2.7-д “Төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана”, 3.3.3.5-д “Төв, орон нутгийн бүх түвшинд үндэсний нийтлэг эрх ашиг сонирхол, төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг дээдэлнэ” хэмээн заасны дагуу ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж хэрэгжүүлэх зорилго бүхий Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг,</p>
------------	--

ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдийн зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн албаны хууль тогтоомж удаа дараа шинэчлэгдэн улам бүр боловсронгуй болж буй эрх зүйн шинэчлэл, шинэтгэлийн үед Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сониход захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх төрийн албаны эрхэм зорилгын хүрээнд төрийн албаны зарчмыг үйл ажиллагаандаа чанд баримтлан ёс зүй, сахилга хариуцлагыг төрийн байгууллагын бүх шатанд мөрдүүлэх, иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх асуудал тасралтгүй зорилт болж ирсэн.

Миний бие төрийн албаны анхан шатны нэгж болох хороо хариуцсан зохион байгуулагчаас ажлын гараагаа эхэлж Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа хүний нөөцийн хэлтсийн даргаар ажиллах хугацаанд төрийн албаны хууль тогтоомжийн хүрээнд уламжлал шинэчлэлийг хамт олонтойгоо хамтран хэрэгжүүлж ирсэн төрийн албаны мэргэшсэн албан хаагч.

Өнөөдөр Монгол Улс төдийгүй дэлхий нийтийг хамарсан амьдралын хэв маягийн эрс өөрчлөлт, цахим шилжилт, хувьсан өөрчлөгдөж байгаа цоо шинэ нөхцөл байдалтай уялдуулан зохистой хариу үйлдэл цаг тухайд нь хийж чадахуйц байхаар төрийн албыг шинэтгэх асуудалд анхаарлаа хандуулж ажиллана.

Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдал шатлан дэвшүүлэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг оновчтой болгох, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой салбарын хуулиудад янз бүрээр тусгасан тэгш бус байдлыг арилгах, төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулах, томилохдоо сонгон шалгаруулалтад ороогүй, төрийн албаны тусгай шаардлага хангаагүй хүнийг шууд томилох, хууль бусаар ажлаас чөлөөлөх, халах тохиолдол байгааг таслан зогсоох чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг уг албан тушаалын чиг үүргийн хүрээнд бүтээлчээр хэрэгжүүлж ажиллах болно.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Баяр

Өөрийн нэр: Пүрэвдагва

Гарын үсэг:

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр